



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2012 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот


Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар
байгуулах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын "ж" заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75, 77 дугаар зүйл, Нийслэлийн Засаг даргын 2012 оны 1/186 тоот албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:



Нэг. Улаанбаатар хотын нийтийн зориулалттай орон сууц, барилга байгууламжийн цахилгаан шатны ашиглалт, засвар үйлчилгээг хариуцах нийслэлийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг байгуулсугай.

Хоёр. Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын бүтэц, орон тоо, дүрмийг баталж, удирдлагыг томилохыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Г.Мөнхбаяр/-д үүрэг болгосугай.

ТЭРГҮҮЛЭГЧ



Ц.ЦОГЗОЛМАА



1110100016



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2012 оны 03 сарын 15 өдөр

Дугаар

4/184

Улаанбаатар хот

“Улаанбаатар лифт” НӨҮГ-ын дүрэм,
бүтэц, орон тоог батлах,
даргыг томилох тухай

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль” -ийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ийн “в”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйл, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Улаанбаатар хотын нийтийн зориулалттай орон сууц, барилга байгууламжийн цахилгаан шатны талаархи бодлого хэрэгжүүлэх, захиалагчийн хяналт тавих, ашиглалт, засвар үйлчилгээг хариуцах “Улаанбаатар лифт” НӨҮГ-ын дүрмийг нэгдүгээр хавсралтаар, бүтэц орон тоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Улаанбаатар лифт” НӨҮГ-ын даргаар Шатархүү овогтой Жаргалсайханыг 2012 оны 3 дугаар сарын 19 ны өдрөөс эхлэн томилж, үндсэн цалинг 650000 /зургаан зуун тавин мянган төгрөгөөр/ тогтоосугай

3. Батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан ажилчдыг томилох, цалин нэмэгдлийг тогтоох, байгууллагын дотоод журмыг батлан, мөрдүүлж ажиллахыг “Улаанбаатар Лифт” НӨҮГ –ын дарга Ш. Жаргалсайханд үүрэг болгосугай.

4. “Улаанбаатар лифт” НӨҮГ-ын ажлын байр, үйлдвэрийн цехийн барилгын газрын асуудлыг нэгдүгээр улиралд багтаан шийдвэрлэхийг Нийслэлийн Өмчийн харилцааны газар /Ц. Баасанжав/-т, Нийслэлийн Газрын алба /Ц. Сандуй/-нд тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын алба /Ч. Бат/-д даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧИЙН

Г.МӨНХБАЯР

НЗДТГ Архив 32	ХУУЛБАР ҮНЭН 2012 он 04 сар 04 өдөр
----------------------	---



111020000685

Нийслэлийн Засаг даргын 2012 оны
03.09.10-ны сарын 15-ны өдрийн
41184-р захирамжийн хавсралт

**"УЛААНБААТАР ЛИФТ" НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрэм нь Улаанбаатар хотын нийтийн зориулалттай орон сууц, барилга байгууламжид ашиглагдаж байгаа болон ашиглалтад орох лифтийн туршилт, тохируулга, магадлал, хяналтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагааны чиглэл, удирдлагын бүтэц, тэдгээрийн эрх үүргийг тодорхойлсон эрх зүйн баримт бичиг мөн.


1.2. Улаанбаатар лифт нийслэлийн өмчит үйлдвэрийн газар нь /цаашид газар гэх/ Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, мөрийн хөтөлбөр, энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

1.3. Газрын үндсэн зорилго нь /орчин үеийн шинэ техник технологи бүхий үйлдвэрлэлийн цех бий болгож шинэ техник технологи нэвтрүүлэх, лифтийн ашиглалт, засвар үйлчилгээг гэрээгээр хариуцах, үйлдвэрлэлийн цехийн тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд аж ахуйн гэрээний үндсэн дээр лифтийн магадлал туршилтын ажлыг гүйцэтгэх, улс орон нутгийн төсвөөр шинэчлэгдэж буй лифтийн зураг төсөв боловсруулах, захиалагчийн хяналт хийх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, сургах зэргээр иргэд, оршин суугчдийн аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэн, шинэ техник технологи нэвтрүүлэх, төсөл боловсруулж хэрэгжүүлэхэд оршино.

1.4. Байгууллага нь өөрт олгогдсон эд хөрөнгө, эрх хэмжээний хүрээнд өөригөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж, бие даан иргэний харилцаанд ордог ашгийн төлөө хуулийн этгээд мөн.

1.5. Газар нь өөрийн нэр бүхий тамга тэмдэг, бэлэгдэл, албан бичгийн хэвлэмэл хуудас, банкинд харилцах данстай байна.

1.6. Газар нь Баянзүрх дүүргийн Намьянжуугийн гудамж XIII дугаар хороололын XV хорооны 6-р байрны зүүн талд байрлах хуучин өрхийн эмнэлгийн барилгад байрлана. Утас 99118545, 481226.



Хоёр: Удирдлага, зохион байгуулалт

2.1. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг шийдвэрлэнэ.

2.2. Газрын даргыг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч томилж, чөлөөлнө.

2.3. Газар нь үйл ажиллагаагаа Нийслэлийн Засаг дарга, Улаанбаатар хотын ерөнхий менежер, Өмчийн харилцааны газрын удирдлага дор явуулж ажлаа тайлагнана.

2.4. Газрын дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч баталж Ерөнхий менежер хяналт тавина.

2.5 Дарга нь хууль тогтоомж болон Нийслэлийн Засаг даргатай байгуулах бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ, Өмчийн харилцааны газартай байгуулах контрактад заасан эрх хэмжээний хүрээнд тус байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

2.6 Даргын эдлэх эрх, хүлээх хариуцлага, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, урамшуулах зэрэг асуудлыг нийслэлийн Засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ, Өмчийн харилцааны газартай байгуулах контрактад тусгана.

2.7 Газрын дарга нь байгууллагын дотоод журам боловсруулан баталж мөрдүүлэн, бүтэц, орон тоо, цалин, урамшууллын хэмжээг тогтоож олгоно.

2.8 Газрын дарга нь эрх хэмжээнийхээ хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлан, ажилтныг ажилд томилж, хөдөлмөрийн гэрээ байгуулж, хууль тогтоомжийн хүрээнд ажлаас чөлөөлнө.


Гурав. Газрын эрх хэмжээ

3.1 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг байгуулах тухай үүсгэн байгуулагчийн шийдвэр гарсан өдрөөс байгуулсанд тооцож, холбогдох хуульд заасан журмаар бүртгүүлж, хуулийн этгээдийн эрхтэй болно.

3.2 Газар нь засвар үйлчилгээний болон дотоодын ажил үйлчилгээнийхээ үнэ тарифыг Нийслэлийн өмчийн харилцааны газар болон Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай зөвшилцөн эрх бүхий байгууллагаар батлуулан, мөрдүүлнэ.

3.3 Ажил үйлчилгээ үзүүлсний үр дүнд олсон ашгийг эрх бүхий байгууллагаас тогтоосон норматив хэмжээгээр үлдээж, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулна.

3.4 Нийслэлийн Өмчит Үйлдвэрийн Газрын дүрмэнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа Нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлнэ.



Дөрөв. Газрын үүрэг

4.1 Газар нь лифтийн ашиглалт, засвар үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, шинэ техник технологи нэвтрүүлэх, бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх зөвлөмж, аргачлал, удирдамж боловсруулж ажиллана.

4.2 Газар нь олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд аж ахуйн гэрээний үндсэн дээр лифтийн магадлал туршилтын ажлыг Улаанбаатар хотын нийт лифтэнд хэрэгжүүлнэ.

4.3 Улс орон нутгийн төсвөөр шинэчлэгдэж буй лифтийн зураг төсөв боловсруулах, захиалагчийн хяналт хийх ажлыг зохион байгуулна.

4.4 Лифтийн ашиглалт үйлчилгээний салбарыг мэргэжилтэй боловсон хүчнээр бэхжүүлэх, тэдний мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, гадаад дотоодын сургалтанд хамруулах, ажилтнуудыг байнгын курсээр бэлтгэх, давтан сургах зэрэг боловсон хүчний нэгдсэн бодлого явуулна.

4.5 Газар нь үйлдвэрлэлийн цехийн материаллаг баазыг өргөтгөн, орчин үеийн машин механизм, шинэ техник технологийг нэвтрүүлэн өргөтгөн бэхжүүлж хүчин чадлыг нь бүрэн ашиглаж, лифтийн сэлбэг үйлдвэрлэх, засварлах, угсрах зэргээр аж ахуйн үйл ажиллагаа явуулна.

4.6 Газар нь өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, Нийслэлийн өмч хөрөнгийг хууль тогтоомжид заасан эрх хэмжээний дотор үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмшиж, ашиглана.

4.7 Өмч хөрөнгийн тооллого, тооцоо бүртгэл хөтлөлтийг зохих хууль дүрмийн дагуу хөтөлж, эд хөрөнгө шинээр олж авах, ашиглалтаас хасах, төрийн өмчийн бус этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах, шилжүүлэх болон худалдах, хувьчлахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон энэ талаар мөрдөгдөж буй бусад хууль журмыг баримтална.

4.8 Газар нь хууль тогтоомж, нийслэлээс баримталж буй бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд жилийн болон дунд хугацааны бизнес төлөвлөгөөгөөр зорилго, зорилтоо тодорхойлж, түүнийгээ ханган биелүүлэх үйл ажиллагаа явуулна.


Тав. Өмч хөрөнгө, санхүүгийн бүртгэл, хяналт

5.1. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын өмч хөрөнгө, санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хөтөлж явуулна.

5.2. Газрын санхүүгийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 1-ээс эхэлж 12 дугаар сарын 31-ний өдөр дуусна. Санхүүгийн анхны жил нь байгуулагдсан өдрөөс эхэлж хуанлийн жилийн 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болох ба санхүүгийн сүүлчийн жил нь татан буулгасан өдрөөр дууссанд тооцно.

5.3. Газар нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу орлогын болон бусад татвар хураамжийг төлнө

5.4. Газар нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн тайлан тэнцлийг улирлаар гаргаж холбогдох байгууллагад хүргүүлнэ.



5.5. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хууль тогтоомжид заасан байгууллага хэрэгжүүлнэ.

Зургаа. Хариуцлага

6.1. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын дарга нь Монгол улсын хууль тогтоомж, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн шийдвэр болон холбогдох бусад шийдвэрийн биелэлтийг хэрэгжүүлэх явцад буруу шийдвэр гаргаж бусдад хохирол учруулсан нь шүүхээр тогтоогдсон бол холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

6.2. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын дарга нь эрх мэдлээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглаж байгууллагадаа хохирол учруулсан бол уг хохирлыг байгууллагын дарга өөрийн хөрөнгөөр хариуцна.


6.3. Дарга нь Монгол улсын хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчвөл хариуцлага хүлээлгэнэ.

Долоо. Бусад

7.1. Энэхүү дүрэмд нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

7.2. Дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр зохих байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

7.3. Энэ дүрэмд тусгагдаагүй бусад асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу зохицуулна.



Нийслэлийн Заасаг даргын 2012 оны
03 дугаар сарын 15-ны өдрийн
А/18/дугаар захирамжийн хоёрдугаар
хавсралт

У.11.0011

"Улаанбаатар лифт" НӨҮГ-н
орон тоо, цалингийн тооцоо /жилээр/

№	Албан тушаал	тоо	Сарын цалин	Жилийн цалин
1	Дарга	1	650.000	7.800.000
2	Ерөнхий инженер	1	625.000	7.500.000
3	Ерөнхий нягтлан бодогч	1	625.000	7.500.000
4	Хүний нөөцийн мэргэжилтэн	1	550.000	6.600.000
5	Тооцооны нягтлан бодогч	2	900.000	10.800.000
6	Нярав	1	350.000	4.200.000
7	Хяналтын инженер	3	1.800.000	21.600.000
8	Угсралтын инженер	1	600.000	7.200.000
9	Техникийн бичиг баримтын инженер	1	600.000	7.200.000
10	КИП-автоматикийн инженер	1	600.000	7.200.000
11	Холбооны инженер	1	600.000	7.200.000
12	Электроникийн инженер	1	600.000	7.200.000
13	Орчуулагч /хятад, солонгос, хэлний/	2	1.000.000	12.000.000
14	Ээлжийн инженер	3	1.200.000	14.400.000
15	Механик	8	4.000.000	48.000.000
16	Засварчин	20	6.000.000	72.000.000
17	Токарьчин	1	300.000	3.600.000
18	Мотор ороогч	2	600.000	7.200.000
19	Гагнуурчин	1	350.000	4.200.000
20	Жолооч	3	750.000	9.000.000
	Нийт	55	22.700.000	272.400.000

НЗДТГ
Архив
32

ХУУЛБАР ҮНЭН
2012 оны 04 сар 04 өдөр
Балд